



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний
өдөр

Дугаар 24/27

Улаанбаатар х

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, 24.1.21 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал"-ы тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Тариф шинэчлэн батлах тухай" 50 дугаар тогтоолын 1 дэх заалт "... 1 тонн энгийн хог хаягдлыг булшлах зардлын тарифыг 4,350 төгрөгөөр гэснийг "... 1 тонн энгийн хог хаягдлыг булшлах зардлын тарифыг 6,364 төгрөгөөр..." гэж өөрчлө оруулсугай.
2. Тогтоолд оруулсан өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлалба (Б.Батбямба)-нд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хоты Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА А.БАЯР